

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК
аудитор: Я.Тунгалаг
Утас: 99459698 Цахим хаяг: anu_gantun@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.АНХБАЯР
ТАНАА

2023.02.24 № УВА-2023/02/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яамнаас 5,100.0 мянган төгрөгийн ном, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 30,000.0 мянган төгрөгийн худаг, Боловсрол мэдээллийн технологийн төвөөс 420.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2,591.7 мянган төгрөгийн ном, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс 1,067.2 мянган төгрөгийн газар, төсвийн хөрөнгөөр 28,829.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, ном худалдаж авсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200443

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
Асуудлыг онцолсон хэсэг.....
Аудитын гол асуудал.....
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
4. АУДИТЫН ТАЙЛАН.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			<i>/Төгрөг/</i>
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>110,910,586.03</u>	<u>302,282,822.08</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	179,639,799.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	179,639,799.55
3121	Төгрөг	00.00	179,639,799.55
31211	Төрийн сангийн харилцах	00.00	179,639,799.55
33	АВЛАГА	12,292,447.90	12,292,447.90
335	Бусад авлага	12,292,447.90	12,292,447.90
3352	Хувь хүмүүсээс авах авлага	12,292,447.90	12,292,447.90
35	БАРАА МАТЕРИАЛ	98,618,138.13	110,350,574.63
351	Түүхий эд материал	324,750.00	00.00
35130	Эм боох материал	324,750.00	00.00
354	Хангамжийн материал	98,293,388.13	110,350,574.63
35410	Бичиг хэргийн материал	1,580,400.00	00.00
35420	Аж ахуйн материал	846,680.00	1,051,000.00
35450	Барилгын засварын материал	908,000.00	00.00
35460	Хүнсний материал	506,649.00	13,080,453.00
35470	Бусад хангамжийн материал	94,451,659.13	96,219,121.63
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,434,163,932.85</u>	<u>2,423,603,034.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,434,163,932.85	2,423,603,034.09
392	Биет хөрөнгө	2,394,065,932.85	2,382,437,834.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,384,069,450.18	2,414,069,450.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-177,462,131.90	-222,089,834.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,375,000.02	-10,937,500.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	243,651,587.56	272,640,746.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-137,273,510.41	-161,627,631.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,602,135.63	104,602,135.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-95,753,829.57	-98,778,499.57
39217	Ном	41,607,231.38	49,558,967.34
393	Биет бус хөрөнгө	40,098,000.00	41,165,200.00
39301	Програм хангамж	660,000.00	660,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-660,000.00	-660,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,098,000.00	41,165,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,545,074,518.88</u>	<u>2,725,885,856.17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>247,880.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	247,880.00	<u>00.00</u>
413	Өглөг	247,880.00	<u>00.00</u>
4136	Бусад өглөг	247,880.00	<u>00.00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	247,880.00	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,544,826,638.88</u>	<u>2,725,885,856.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,544,826,638.88	2,725,885,856.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,282,600,835.50	1,282,600,835.50

51101	Өмч: - төрийн	1,282,600,835.50	1,282,600,835.50
512	Хуримтлагдсан үр дүн	593,161,912.52	774,221,129.81
51210	Өмнөх үеийн үр дүн	-173,055,198.64	-173,055,198.64
51220	Тайлант үеийн үр дүн	766,217,111.16	947,276,328.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	669,063,890.86	669,063,890.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,545,074,518.88	2,725,885,856.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,944,941,327.80	1,538,179,002.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	860,983,247.80	42,509,002.46
120	Нийтлэг татварын бус орлого	860,983,247.80	42,509,002.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	860,983,247.80	42,492,302.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	701,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	860,282,247.80	42,492,302.46
120009	Бусад орлого	00.00	16,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	216,122,180.00	1,495,670,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,241,519,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,241,519,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,535,180.00	70,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,535,180.00	70,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	205,587,000.00	254,080,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	205,587,000.00	254,080,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,177,757,179.13	1,357,119,785.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,177,757,179.13	1,357,119,785.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,125,119,577.65	1,329,155,627.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	659,298,056.61	813,099,518.85
210101	Үндсэн цалин	659,298,056.61	622,640,656.19
210102	Нэмэгдэл	00.00	152,700,069.66
210104	Урамшуулал	00.00	36,078,793.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,977,559.51	85,974,724.48
210201	Тэтгэврийн даатгал	46,412,699.78	59,516,163.78
210202	Тэтгэмжийн даатгал	6,490,619.52	7,160,748.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,192,496.62	5,601,520.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,171,066.87	1,255,639.43
210205	Эрүүл мэндийн даатгал	11,710,676.72	12,440,652.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,401,704.00	203,794,430.63

210301	Гэрэл, цахилгаан	6,664,910.00	8,919,790.63
210302	Түлш, халаалт	194,703,794.00	194,791,640.00
210303	Цэвэр, бохир ус	33,000.00	83,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,448,016.00	3,180,900.00
210401	Бичиг хэрэг	6,435,780.00	3,180,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,077,100.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	969,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,288,136.00	00.00
210408	Бараа материал ақталсны зардал	3,128,000.00	00.00
2105	Нормативт зардал	72,907,203.00	104,414,256.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,413,650.00	324,750.00
210502	Хоол, хүнс	71,574,553.00	104,089,506.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,784,000.00	713,500.00
210604	Урсгал засвар	3,784,000.00	713,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,256,950.00	8,333,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,694,500.00	8,333,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,278,688.53	109,645,297.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	22,615,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	3,281,000.00	8,460,534.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,997,688.53	78,568,993.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,637,601.48	27,964,157.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,470,500.00	27,255,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,643,500.00	27,255,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,827,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,167,101.48	709,157.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,167,101.48	709,157.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>767,184,148.67</u>	<u>181,059,217.29</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	967,037.52	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	967,037.52	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-967,037.52	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>766,217,111.15</u>	<u>181,059,217.29</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,096,038,290.00</u>	<u>1,495,686,700.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,080,210.00	16,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,080,210.00	16,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,080,210.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,080,210.00	00.00
120009	Бусад орлого	00.00	16,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,083,958,080.00</u>	<u>1,495,670,000.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,241,519,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,241,519,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	867,835,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,535,180.00	70,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,535,180.00	70,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	205,587,000.00	254,080,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	205,587,000.00	254,080,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,080,938,290.00</u>	<u>1,316,046,900.45</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,080,938,290.00</u>	<u>1,316,046,900.45</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,016,386,488.52</u>	<u>1,268,163,342.96</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	647,385,146.03	799,943,364.66
210101	Үндсэн цалин	438,426,732.25	572,271,166.00
210102	Нэмэгдэл	153,317,987.53	188,233,405.66
210104	Урамшуулал	45,581,426.25	36,078,793.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,059,000.00	3,360,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,951,926.49	99,130,878.67
210201	Тэтгэврийн даатгал	58,092,075.69	70,749,802.63
210202	Тэтгэмжийн даатгал	6,410,606.49	7,488,619.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,131,511.86	5,980,459.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,210,690.25	1,328,888.67
210205	Эрүүл мэндийн даатгал	12,107,042.20	13,583,109.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,523,104.00	202,377,990.63
210301	Гэрэл, цахилгаан	6,664,910.00	8,919,790.63
210302	Түлш, халаалт	195,825,194.00	193,375,200.00
210303	Цэвэр, бохир ус	33,000.00	83,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,125,880.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,292,180.00	00.00

210402	Тээвэр, шатахуун	4,350,700.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	805,700.00	00.00
210404	Ном, хэвлэл	780,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,259,400.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,637,900.00	00.00
2105	Нормативт зардал	58,079,982.00	93,437,245.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	974,100.00	
210502	Хоол, хүнс	56,295,882.00	93,437,245.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	810,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,482,500.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	2,482,500.00	2,500,000.00
210702	Дотоод албан томилолт	767,400.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,756,950.00	8,333,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,194,500.00	8,333,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,313,600.00	62,440,864.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	49,770,830.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,313,600.00	12,670,034.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,551,801.48	47,883,557.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,384,700.00	47,174,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,037,700.00	47,174,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,347,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,167,101.48	709,157.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,167,101.48	709,157.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>15,100,000.00</u>	<u>179,639,799.55</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	179,639,799.55
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	179,639,799.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,282,600,835.50	669,063,890.86	593,161,912.52	2,544,826,638.88
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,282,600,835.50	669,063,890.86	593,161,912.52	2,544,826,638.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,282,600,835.50	669,063,890.86	593,161,912.52	2,544,826,638.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	181,059,217.29	181,059,217.29
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,282,600,835.50	669,063,890.86	774,221,129.81	2,725,885,856.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦӨВЭР ЗӨСЛИЙН ДҮН	1,498,238,400.00	1,315,728,842.96	182,509,557.04
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,498,238,400.00	1,315,728,842.96	182,509,557.04
210	Бараа, үйлчилгээний зардал	1,443,961,300.00	1,268,554,442.96	175,406,857.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	915,094,500.00	799,943,364.66	115,151,135.34
210101	Үндсэн цалин	701,366,100.00	572,271,166.00	129,094,934.00

210102	Нэмэгдэл	192,061,100.00	188,233,405.66	3,827,694.34
210104	Урамшуулал	18,307,300.00	36,078,793.00	(17,771,493.00)
210105	Гэрээт ажлын хөлс	3,360,000.00	3,360,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,311,100.00	99,130,878.67	15,180,221.33
210201	Тэтгэврийн даатгал	77,818,700.00	70,749,802.63	7,068,897.37
210202	Тэтгэмжийн даатгал	9,155,100.00	7,488,619.07	1,666,480.93
210203	ҮОМШӨ ний даатгал	7,324,000.00	5,980,459.24	1,343,540.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,819,400.00	1,328,888.67	490,511.33
210205	Эрүүл мэндийн даатгал	18,193,900.00	13,583,109.06	4,610,790.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,087,000.00	202,377,990.63	709,009.37
210301	Гэрэл цахилгаан	8,700,000.00	8,919,790.63	(219,790.63)
210302	Түлш, халаалт	194,087,000.00	193,375,200.00	711,800.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	83,000.00	217,000.00
2105	Нормативт зардал	115,885,200.00	93,437,245.00	22,447,955.00
210502	Хоол, хүнс	115,885,200.00	93,437,245.00	22,447,955.00
2106	Эд хогшил худалдан авах	2,500,000.00	2,500,000.00	-
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,256,300.00	8,794,100.00	2,462,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,638,400.00	461,100.00	2,177,300.00
210806	Мэдээллийн технологийн зардал	8,617,900.00	8,333,000.00	284,900.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	81,827,200.00	62,370,864.00	19,456,336.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,900,300.00	49,700,830.00	19,199,470.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,926,900.00	12,670,034.00	256,866.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,277,100.00	47,174,400.00	7,102,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,277,100.00	47,174,400.00	7,102,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	54,277,100.00	47,174,400.00	7,102,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,498,308,400.00	1,498,238,400.00	70,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,244,157,900.00	1,244,157,900.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,244,157,900.00	1,244,157,900.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	254,080,500.00	254,080,500.00	-
132001	Орон нутгийн төсвөөс	254,080,500.00	254,080,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,000.00	-	70,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,000.00	-	70,000.00

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	179,639,799.55	(179,639,799.55)
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61.00	61.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	41.00	41.00	-
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00	-
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь өөрийгөө илэрхийлж бие даан ажиллах чадвар эзэмшсэн, зөв дадалтай хүүхдийг төлөвшүүлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжихэд чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Боловсролын тухай хууль - 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 180,811.3 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	179,639.7	179,639.7
Авлага	12,292.4	12,292.4	0
Бараа материал	98,618.1	110,350.5	11,732.4
Үндсэн хөрөнгө	2,434,163.9	2,423,603.0	-10,560.9
Нийт хөрөнгө	2,545,074.5	2,725,885.8	180,811.3
Өр төлбөр	247.0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,544,826.6	2,725,885.8	181,059.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,545,074.5	2,725,885.8	180,811.3

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 179,639.7 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 110,350.5 мянган төгрөг болж 11,732.4 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан хүнс, бичиг хэргийн материалаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,423,602.0 мянган төгрөг болж 10,560.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,725,885.8 мянган төгрөг болж 180,811.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн нь 180,811.3 мянган төгрөг болж өмнөх оны үр дүнгээс 7.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,495,600.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,495,600.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 424,815.5 мянган төгрөгөөр нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,495,600.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,241,519.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 254,080.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,062,357.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 253,371.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвийн 1,062,357.5 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвийн дансанд 179,162.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвийн 709.1 төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
	Улсын төсвөөс	1,241,519.5	1,062,357.5	179,162.0	85.5%
	Орон нутгийн төсвөөс	254,080.5	254,080.5	0	100%

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,316,438.0 мянган төгрөг буюу 85.5% хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 799,943.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 99,130.8 мянга, үдийн цайны зардлыг

47,174.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 62,370.8 мянга, хүүхдийн хоолны зардлыг 93,437.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,061.3 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 5.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох

шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,075.2 сая төгрөгийн 0.5 хувиар буюу 5.3 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроож 5, хугацаандаа оруулсан 144 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,011.2 мянган төгрөгийн алдаа илэрснийг залрууллаа.

5.1 Залруулсан алдаа

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай 5.1.4 дэх заалтад “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална” гэж заасныг зөрчин 70.0 мянган төгрөгийн зардлыг дутуу илэрхийлснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай 5.1.4 дэх заалтад “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 14.4.4 дэх заалтад “аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчин 2,941.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн бараа материал буруу илэрхийлснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Зардал буруу илэрхийлсэн	1	70.0			1	70.0	1	70.0				
Буруу тусган илэрхийлэгдсэнтэй холбоотой	1	2,941.2			1	2,941.2	1	2,941.2				
Дүн	2	3,011.2			2	3,011.2	2	3,011.2				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М. БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М. БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“УВС ФИНАНС АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТОР

/Я. ТУНГАЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 12-ны өдөр